

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
САНХҮҮ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

НИЙСЛЭЛИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН
САНХҮҮ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ


Шалгалтанд хамрагдсан хугацаа: 2013 он

Шалгалт эхэлсэн огноо: 2014.01.23

Шалгалт дууссан огноо: 2014.02.28

Шалгасан: Улсын ахлах байцаагч

Улсын байцаагч



/ Д.Энхжаргал /

/ Ж.Амаржаргал /

Хуудасны тоо 19.....

Улаанбаатар хот 2014 он

2014 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

**Нийслэлийн Яаралтай Тусламжийн Төвийн 2013 оны санхүү,
аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн тухай**

Нэг. Шалгалтын зорилго

Монгол улсын хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, норм нормативын хэрэгжилт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт олж бэлтгэсэн байдлыг шалган илэрсэн зөрчлийг арилгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 02-02/24 тоот удирдамжийн дагуу Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн 2013 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Энхжаргал, улсын байцаагч Ж.Амаржаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 02 дугаар сарын 28 –ыг хүртэл хугацаанд шалгалт хийлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдах асуудлууд

Шалгалтыг Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Төсвийн тухай” хуулиуд болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, заавар журмын хэрэгжилттэй холбон хийж гүйцэтгэв.

Дөрөв. Шалгагдсан байгууллагын мэдээлэл

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь 9077332 тоот регистрийн дугаартай 9070001108 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй Сүхбаатар дүүргийн 6-р хороо Энхтайвны өргөн чөлөө Чин ван Чагдаржавын гудамжинд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь 1930 оны 10 дугаар сарын 20-нд Ардын Эрүүлийг Хамгаалах Яамны Сайдын тушаалаар Улсын клиникийн төв эмнэлэгээс тусгаарлан гарч 3 бага эмч, 3 асрагч, түргэн тусламжийн 1 морин тэрэгчинтэйгээр бие даасан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Тус төв нь эмнэлгийн яаралтай тусламж, авто аж ахуй хангамж үйлчилгээ гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж их эмч 125, сувилагч дунд мэргэжилтэн 39, жолооч 116, захиргаа аж ахуй болон бусад ажиллагсад 91 нийт 367 ажилтантайгаар

төвийн 6 дүүргийн насанд хүрэгчдэд болон 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн хүүхдийн дуудлага, бусад 4 дүүргийн 16 хүртэлх насны осол гэмтлийн дуудлаганд 24 цагаар үйлчилж ажил үйлчилгээ явуулдаг байна.

Яаралтай түргэн тусламжийн төв нь хоногт дунджаар хүүхдийн 38737 дуудлага, насанд хүргэгчдийн 236522 дуудлага хүлээн авч үйлчилдэг бөгөөд зүрх судас, эрчимт эмчилгээ, мэдрэл, осол гэмтэл, төрөх эмэгтэйчүүд зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын баг иргэдэд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх тусламж үзүүлдэг байна.

Яаралтай түргэн тусламжийн төвийн салбар төвүүдийн талаар:

Баянзүрх салбар: 2010 оны 12 дугаар сарын 13-ний өдрөөс тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлан тус дүүргийн 23 хорооны насанд хүрэгчдийн дуудлаганд, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүүхдийн дуудлаганд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлж байна. Тус салбар нь 2 давхар байшинтай 12 автомашины дулаан зогсоолтой байна.

Сонгинохайрхан салбар: 2012 оны 1 дүгээр сард ашиглалтанд орж дүүргийн 34 хорооны 252,3 мянган хүн амд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг.

Харилцах данс, хөрөнгө мөнгө захиран зарцуулах эрхийн талаар.

Шалгалтанд хамрагдах хугацаанд Нийслэлийн Төрийн сангийн 200020006, 200020406 тоот дансны баримтанд нэгдүгээр гарын үсгийг захирал Ц.Пүрэвдаш, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Отгонтэнгэр нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Тав: Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалтын талаар

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан удирдамжийн дагуу 2011-2012 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж 5 актаар 9.029,343 төгрөгийн акт тогтоосныг барагдуулсан байна.

Урьд онуудын шалгалтаар тогтоогдсон актын төлбөрийн үлдэгдэл 202,5 мянган төгрөгийг барагдууллаа.

Зургаа: Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн байдлын талаар

Санхүүгийн хяналт шалгалтаар: Шалгалтанд орлого төлөвлөлт, зарцуулалт, харилцах дансны ажил гүйлгээ, бэлэн мөнгөний зарцуулалт, цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад нэмэгдлүүдийн тогтоолт, тооцоололт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татвар ногдуулалт, дараа тайлангийн тооцоо, өр авлага үүсгэсэн байдал, барагдуулалт, тэдгээрийн үлдэгдлийн баталгаажуулалт, бараа материал олж бэлтгэсэн байдал, зарцуулалт, үндсэн хөрөнгийн тооллого тооцоо бодолт, хөрөнгө

оруулалт болон хандив тусламжийн хөрөнгийн бүртгэл, түүний ашиглалт, зарцуулалт, үндсэн хөрөнгийн өөрчлөлт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тэдгээрийн тайлан тэнцэлд тусгасан байдал, санхүүгийн үр дүнг хамруулав.

Шалгалтын явцад төвийн харьяа салбар төвүүдийн үйл ажиллагаатай танилцан газар дээр нь танилцан авто бааз, захиргаа, Баянзүрх, Сонгинохайрхан төвүүдэд хэсэгчилсэн тооллого, касс, шатахууны талон, сэлбэг хэрэгслийн /склады/ үлдэгдлийг тоолоход дутагдал илрээгүй, шатахууны талоны үлдэгдэл 33.300,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр таарч байсан. /Улаанбаатар хотын Гамшгаас хамгаалах салбар зөвлөлийн төлөвлөгөөний дагуу шатахууны үлдэгдэлтэй байдаг байна/. Мөн гражийн ашиглалтын байдалд гэнэтийн шалгалт хийж гэрээтэй нь тулгахад 5 тээврийн хэрэгслийг гэрээгүй тавиулсан байна.

Тус төвийн 40 жолоочоос тээврийн болон жолоочийн хариуцлагын даатгал, илүү цаг, урамшуулал олголтын талаар санал асуулга авахад жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан талаар мэдэхгүй 3 буюу 7.5%, илүү цагийн хөлс олгодоггүй 8 буюу 20%, урамшуулал олгохдоо ажлын харгалздаггүй гэж 2 буюу 5.0% нь хариулсан байна. Санал асуулгаас харахад цалин хөлс, урамшуулал олголтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч цалингийн картыг ажилтан тус бүрээр хөтлөж баталгаажуулан ажиллах шаардлагатай байна.

Тус төвийн санхүү аж ахуйн ажилтан, хүний нөөц болон холбогдох албан тушаалтан нарт нягтлан бодох бүртгэл болон холбогдох хууль, тогтоомж заавар журмын хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгч ажилласан.

Долоо. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн талаар

7.1 Орлогын эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар

	Эх үүсвэр	Мянган төгрөг			
		2012 он		2013 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Төсвийн санхүүжилт	4,661,900.0	4,661,900.0	5,469,094.2	5,469,094.2
2	Үндсэн үйл ажиллагааны орлого	44,000.0	45,000.2	44,000.0	27,284.8
	Нийт дүн	4,705,900.0	4,706,900.2	5,513,094.2	5,496,379.0

2013 онд төсвөөс 5,469,094.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 44,000.0 мянган төгрөг нийт 5,513,094.2 мянган төгрөгөөр санхүүжилт авахаас гүйцэтгэлээр төсвөөс 5,469,094.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 27,284.8 мянган төгрөг нийт 5,496,379.0 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

7.2 Зардлын зарцуулалтыг авч үзвэл:

/Мянган төгрөг/

Зардлын нэр	2012 он		Хэтрэлт\-\ Хэмнэлт\+\	2013 он		Хэтрэлт\-\ Хэмнэлт\+\
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Цалин хөлс нэмэгдэл зардал	3,404,035.8	3,383,469.3	21,566.5	4,014,198.7	4,012,144.3	2,054.4
НДШ-ийн зардал	337,928.7	341,851.7	-3,967.0	441,562.0	425,666.7	15,895.3
Гэрэл цахилгааны зардал	19,631.9	19,316.5	315.3	18,782.0	19,177.4	-395.4
Түлш халаалтын зардал	38,176.2	32,222.2	5,954.0	34,440.8	32,886.4	1,554.4
Цэвэр бохир усны зардал	5,857.0	5,857.0	0.0	6,871.1	7,889.8	-1,018.7
Бичиг хэргийн зардал	19,190.5	19,781.3	-590.8	23,918.3	23,839.7	78.6
Тээвэр шатахууны зардал	697,929.6	699,063.3	-1,133.7	779,030.2	779,187.7	-151.5
Шуудан холбоон зардал	9,674.8	9,511.3	163.5	9,741.8	9,741.8	0.0
Дотоод томилолтын зардал	9,951.8	6,964.6	-12.8	7,730.4	7,576.5	153.9
Ном хэвлэлийн зардал	287.2	272.2	15.0	287.2	287.2	0.0
Эмийн зардал	89,810.6	89,482.1	328.5	97,880.1	98,155.3	-275.2
Эд хогшил худалдан авах зардал	14,670.4	14,689.5	-19.1	15,076.4	15,062.2	14.2
Норм хувцас авах зардал	17,896.4	20,012.4	-2,116.0	19,111.4	19,190.0	-78.6
Урсгал засварын зардал	6,000.0	5,992.4	7.6	6,000.0	5,878.3	121.7
Төлбөр хураамж бусад зардал	16,146.4	16,144.4	2.0	16,146.4	15,871.2	275.2
Тээврийн хэрэгсэл	711.0	690.9	20.2	1,361.0	1,361.0	0.0
ТӨГА үйлчилгээ	15,526.4	17,434.1	-1,907.7	16,340.2	16,138.2	202.0
Газрын төлбөр	2,484.4	2,440.7	43.7	2,484.4	2,484.4	0.0
Урьд оны хэмнэлтийн зарцуулалт	0.0	1,640.5	-1,640.5	0.0	1,036.0	-1,036.0
1 удаа тэтгэмжийн зардал	2,991.0	2,988.9	2.1	2,131.8	2,131.8	0.0
Төвлөрүүлэн шилжүүлэг	0.0	71,914.8	-71,914.8	0.0	1,709.0	-1,709.8
Нийт дүн	4,661,900.0	4,762,784.0	-16,446.2	5,513,094.2	5,497,415.0	18,424.3

Зардлын бүтцийн талаар:

2013 оны нийт зардлын 81.8 хувь буюу 4,497,764.6 мянган төгрөгийг/ цалин, нийгмийн даатгалын шимтгэл, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардал/, 14,2 хувь буюу 779,187.7 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардал, 1.8 хувь буюу 98,155.3 мянган төгрөгийг эмийн зардал, 0,3 хувь буюу 19,190.0 мянган төгрөгийг эд хогшил худалдан авах зардал, 3.6 хувь буюу 201,272.7 мянган төгрөгийг бусад эзэлж байна.

Тээвэр шатахууны зардалд: 586.063,0 мянган төгрөгийн шатахуун, 55.000,0 мянган төгрөгийн шатахууны талон, 138.124,7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал, нийт 779.187,7 мянган төгрөгийг тус тус тусгасан байна.

Зардлын зүйлийн талаар:

Зардлын хэтрэлт хэмнэлтийг авч үзвэл: 2013 онд 5 нэр төрлийн зардал 78.6-1,018.7 мянган төгрөгөөр хэтэрч, 9 нэр төрлийн зардал 14.215,895.3 мянган төгрөгөөр хэмнэгдэн зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

2013 онд хэтэрсэн зардлуудыг авч үзвэл: гэрэл цахилгааны зардал 2.1 хувь буюу 395.4 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардал 12.9 хувь буюу 1,018.7 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 0.1 хувь буюу 151.5 мянган төгрөгөөр, эмийн

зардал 1.3 хувь буюу 275.2 мянган төгрөгөөр, нормын хувцас худалдан авах зардал 0.5 хувь буюу 78.6 мянган төгрөгөөр тус тус хэтэрч, цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.0-3.6 хувиар буюу 2,054.4- 15,895.3 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 4.7 хувь буюу 1,554.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 0.3 хувь буюу 78.6 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 2.0 хувь 153.9 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 0.1 хувь буюу 14.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 2.0 хувь буюу 121.7 мянган төгрөгөөр, төлбөр хураамж болон бусад зардлыг 1.7 хувь буюу 275.2 мянган төгрөгөөр, ТӨГАҮ-ний зардлыг 1.2 хувь буюу 202.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тус төв нь Сангийн сайдын 2013 оны 73 тоот “Журам батлах тухай” тушаалын 1 хавсралт 2-д төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5-д заасны дагуу зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

7.3 Үндсэн хөрөнгийн талаар

Хөрөнгийн нэр	2013 оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		2013 оны эцсийн үлдэгдэл
		Нэмэгдсэн	Хасагдсан	
Барилга байгууламж	3,635,334.6	55,000.0		3,690,334.6
Тээврийн хэрэгсэл	1,095,926.5	1,819,767.4	184,680.9	2,731,013.0
Тоног төхөөрөмж	644,145.0	459,878.2	28,000.0	1,075,423.2
Тавилга эд хогшил	110,925.6	5,101.0		116,026.6
Бусад үндэн хөрөнгө	128,610.2			128,610.2
Биет бус хөрөнгө	4,413.7			4,413.7
Нийт Дүн	5,619,355.8	2,339,746.7	213,280.9	7,745,821.6

2013 онд 5,619,355.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлангийн хугацаанд үндсэн хөрөнгө 2,339,746.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 213,280.9 мянган төгрөгөөр хасагдаж жилийн эцэст 7,745,821.6 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

Нэмэгдсэн барилга байгууламжийн тухай.

Нийслэлийн яаралтай тусламжийн төв нь Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дээврийн их засварын ажлыг 55,000.0 мянган төгрөгөөр хийгдснийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2013 оны 09 дүгээр сарын 25-ны А/469 тоот тушаалаар данс бүртгэлд тусгасан байна.

Нэмэгдсэн тээврийн хэрэгсэлийн тухай.

Тус төв нь Нийслэлийн хөрөнгө оруулалтаар нэг бүр нь 48,333.3 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 1,867,000.0 мянган төгрөгийн Хьюндай Старекс маркийн тоногдосон 30 ш тээврийн хэрэгсэл, Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн Тоёото гранвиа маркийн /хуучин/ 7,806.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Монголын мянганы сорилтийн сангийн хандив тусламжаар өгсөн 233,309.4 мянган төгрөг Форд маркийн нийт 1 ширхэг тээврийн хэрэгслийг Нийслэлийн өмчийн

харилцааны газрын 2013 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн А/61, А/356, А/ 419 тоот тушаалаар хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байна.

Мөн онд Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлээс Жимбей, Тиома, Химейдик, Фургон, Тиана жийп, Старекс, Пропокс маркийн 137,652.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэн өгснийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2013 оны 06 дугаар сарын 07-ний А/571 тоот тушаалаар данс бүртгэлд тусган ажилласан байна.

Нэмэгдсэн тоног төхөөрөмжийн тухай:

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 429,000.0 мянган төгрөгийн 30 ширхэг түргэний автомашины эмнэлгийн тоног төхөөрөмж, Мянганы Монголын сорилын сангаас 13 нэр төрлийн 19,540.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 12 нэр төрлийн 11,338.2 мянган төгрөгийн /компьютер Dell-i5, компьютер-3ш, өнгөт болон хар принтер, 2 дугаар хоолны тогоо 2, баримт үдэгч, факсын аппарат, цаас хэрчигч/ зэрэг бүгд 459,878.2 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэн данс бүртгэлд тусгасан байна..

Нэмэгдсэн тавилга,эд хогшлийн тухай:

Төсвийн хөрөнгөөр 5,101.0 мянган төгрөгийн / хувцасны төмөр шкаф 6 нүдтэй-10 ширхэг, бичгийн ширээ-3 ширхэг, хүлээлгийн сандал 2 хос, гал тогооны ширээ-3 ширхэг, ариутгалын ширээ-1/ тавилга эд хогшлийг худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Хасагдсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар:

Нийслэлийн яаралтай тусламжийн төв нь Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2013 оны А/297, А/645 тоот шийдвэрийн дагуу ашиглалтын хугацаа дууссан 6 ш 88,614.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслэлийг дуудлага худалдаагаар оруулан худалдан борлуулж данснаас хассан. Худалдан борлуулсан хөрөнгөөс 5005.0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

2013 онд нийслэлийн хөрөнгө оруулалтаар авсан Хьюндай Старекс маркийн 96,066.6 мянган төгрөгийн 2 авто тээврийн хэрэгсэл, 28,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Нийслэлийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 05-ний А/369 тоот захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2013 оны 05 дугаар сарын 31-ний А/227 тоот зөвшөөрийн дагуу Гацуурт, Туул тосгоны эмнэлэгт үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгснийг данс бүртгэлээс хассан байна.

7.4 Өр, авлагын талаар

№	Үзүүлэлт	2013 оны эхэнд	Өөрчлөлт		2013 оны эцэст
			Нэмэгдсэн	Хасагдсан	
	Авлагын нийт дүн	21,414.7	422.4	9,369.7	12,467.4
1	Байгууллагаас авах авлагын дүн	9,943.5	0.0	9243.5	700.0
	Алтан дуулга ХХК /Батсайхан/	700.0			700.0

	Шатахууны авлага /Дэлгэрширээт/	9243.5		9243.5	0.0
2	Хувь хүмүүсээс авах авлага	11,471.2	422.4	126.2	11,767.4
	Цулбуур / Иргэн /	10,000.0			10,000.0
	Сэлбэгийн авлага иргэн	1,345.0			1,345.0
	Билгүүн /05-73 УНБ/	0.0	422.4		422.4
	Ажилчдаас авах авлага	126.2		126.2	0.0
	Өр төлбөрийн нийт дүн	0.0	0.0	0.0	0.0

2013 онд нийт авлагын 52.8 хувь буюу 9,369.7 мянган төгрөгийг барагдуулж 12,467.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ажилласан байна.

Нийт авлагын 91 хувь буюу 11,345.0 мянган төгрөг нь 2006 онд, 5.6 хувь буюу 700.0 мянган төгрөг нь 2011 онд, 3.4 хувь буюу 422.4 мянган төгрөг нь 2013 онд үүссэн байна. Тус төв нь авлага барагдуулах ажил зохион байгуулж 2 иргэнтэй холбоотой 11,345.0 мянган төгрөгийг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь 2013 онд өр төлбөргүй ажиллажээ.

Найм: Шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдал, хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт

10.1 Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр:

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь тайлан тэнцлийг хуулийн хугацаанд холбогдох газруудад тайлагнан тушааж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Санхүүгийн тооцоолох ХХК-ны санхүүгийн программыг хэрэглэсэн байна.

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн хэрэгжилтийн талаар.

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 6.4.8-д " төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс нь 12,467.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчин жолооч Түвшин нь өөрийн буруугаас зам тээврийн осол гаргаж байгууллагад 1,074.4 мянган төгрөгийн хохирол учруулсан гэж нөхөн төлбөрийн акт тогтоосон байхад төлбөрийг байгууллагаас төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Мөн гэрээт харуул хамгаалалтын 12 ажилтанд урамшуулалд 2,851.0 мянган төгрөгийг олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар :

Тус төвийн жолооч нарын 2013 оны 1 удаагийн тооцоо бодолтыг 82 жолооч тус бүрээр 82 жолоочийн замын тооцооны хуудас, 502 замын дагалдахыг үндэслэн шатахуун, шатахууны талоны олголт, шатахуун, шатахууны талоны зарлагатай нэгбүрчлэн тулган шалгахад 18 жолооч дээр 183 литр шатахууны 323,8 мянган

төгрөгийн, мөн 5 албан тушаалтны /дэд захирал, ерөнхий инженер, шалгах механик, 2 жолооч / бүтэн жилийн тооцоог шалгахад 644 литр шатахууны 1337,1 мянган төгрөг бүгд 827 литр шатахууны 1,660.9 мянган төгрөгийн шатахуун болон шатахууныг талоньг жолоочийн тооцооны хуудас, замын дагалдах хуудасгүйгээр зарцуулсан нь Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ.” гэсэн заалтуудыг зөрчсөн. /Хавсралт үзнэ үү/

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар.

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч 2013 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1,925,000.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 16,439.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг авч ажилласан байна.

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Тус төв нь Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлдэг тендерт шалгарсан 18 аж ахуйн нэгж 23 багцийн 98,155.3 мянган төгрөгийн эм, боох материалыг худалдан авсан байна.

Мөн авто тээврийн хэрэгслийн сэлбэгийг худалдах авахдаа “Монгол Хьюндай” ХХК, “Эм Эй Кэй” ХХК-уудаас үнийн судалгаа авч, харьцуулалт хийж “Эм Эй Кэй” ХХК-ийг сонгож, худалдах худалдан авах гэрээ хийж, 2013 онд нийт 49.236,6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авжээ.

Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын хэрэгжилтийн талаар :

Тус байгууллага нь 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Автомашинь 100 километр гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 5 дугаар хавсралт “Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцлийг харгалзан авто машинь шатахуун зарцуулалтын үндсэн нормьг нэмэгдүүлэх тусгай нөхцөл”-ийг үндэслэн Хүн эмнэлгийн түргэн тусламжийн үүрэг гүйцэтгэж явсан гүйлтэд шатахуун зарцуулалтын үндсэн нормьг 15%-иар, 4 дүгээр хавсралт “ Автомашинь шатахуун зарцуулалтын үндсэн нормьг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээ, мөрдөх хугацааг үндэслэн 10 дугаар сарын 15-наас 4 дүгээр сарын 20-н хүртэл 5,5 %-иар тус тус нэмэгдүүлэн зарцуулахаар тушаал гарган ажилласан байна.

Нийслэлийн Яаралтай тусламжийн төв нь 2013 онд Монгол даатгал ХХК-тай гэрээ байгуулан 53 тээврийн хэрэгслийн даатгалд 10020.0 мянган төгрөг, 107 жолоочийг жолоочийн хариуцлагын даатгалд хамруулан 5346.0 мянган төгрөгийг төлж, даатгалын нөхөн олговорт 14 тээврийн хэрэгсэлд 7522.6 мянган төгрөг, 16 жолоочийн хариуцлагын даатгалд 7871.6 мянган төгрөгийн нөхөн олговрыг тус тус авсан байна.

Түрээсийн төлбөр тооцооны талаар.

2013 онд Монгол улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2004 оны 563 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн Өмчийн харилцааны газартай гэрээ байгуулан авто машины дулаан гражийг түрээслүүлэн түрээсийн орлогын 60% болох 10,444.8 мянган төгрөгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт төвлөрүүлсэн байна. Шалгалтын хугацаанд баазын дулаан гражийн ашиглалтын байдалд гэнэтийн шалгалт хийж гэрээтэй нь тулгахад 5 тээврийн хэрэгслийг гэрээгүй тавиулж 1,404.0 мянган төгрөгийн гражийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ. Хавсралт үзнэ үү\

Байгууллагын ололт, амжилтын талаар.

Санхүүгийн хяналт шалгалтаар: 2013 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар эмнэлэг үйлчилгээнд зориулж иж бүрэн тоноглогдсон “Старикс” маркийн 30 автомашин хүлээн авч парк шинэчлэл хийж, иргэд үйлчлүүлэгчдэд чиглэсэн “Амилуулах суурь тусламж”-ийн онол дадлагын танхим, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн салбарт хүүхдийн үзлэгийн өрөөг “Хүүхдэд ээлтэй, айдасгүй үзлэгийн орчин”-оор тохижуулан ажиллажээ.

Төв нь ХБНГУ-ын Эссан хотын аврах алба, Эссан хотын Их сургуулийн эмнэлэгтэй хамтран “Эмнэлэгийн дотоод халдвараас хамгаалах”, эмнэлгийн туслах ажилтан /парметик/ -ийн хөтөлбөрт сургалтыг үе шаттайгаар явуулж иржээ.

Ёс. Шалгалтаар авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа зөвлөгөө өгсөн байдлын талаар

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр: Хөрөнгө мөнгийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнууд, санхүү аж ахуйн ажилтнуудад сургалт зохион байгуулж, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж заавар журмыг танилцуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Арав. Дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр шалгалтанд хамрагдсан хугацааны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар дарга нягтлан бодогч нар нь төсвийг үр ашигтай зарцуулах талаар нэлээд анхаарч, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих заавар журмын дагуу хөтлөн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд холбогдох газруудад тайлагнан тушааж, албан хаагчдыг сургаж,

чадваржуулах, ажил үйлчилгээний хүртээмж дээшлүүлэх, мөн гадаад дотоодын олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэн ажилласан байна. Тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, зохих шатны байгууллагаар баталгаажуулж хэвшсэн байна.

Тус байгууллага нь шалгалтанд хамрагдсан хугацааны санхүү аж ахуйн үйл ажиллагааг “Төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ны дагуу шалгаж дүгнэхэд 29 оноо авч бага эрсдэлтэй гэж үнэлэгдлээ.

Шалгалтаар 3 салбар актаар 6.990,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон болно.

Арван нэг: Цаашид анхаарч ажиллах зүйл

- Санхүү бүртгэлийн холбоотой хууль тогтоомж, тушаал шийдвэр, заавар журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.
- Байгууллагын дотоод журмыг хууль, засгийн газрын тогтоолын хүрээнд шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах.

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Д.ЭНХЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.АМАРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.ОТГОНТЭНГЭР